148

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 08 өдөр Дугаар 07 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагыг
магадлан итгэмжлэх шалгуур
үзүүлэлт батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг нэгдүгээр, нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг хоёрдугаар, сум дундын эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг гуравдугаар, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг дөрөвдүгээр, өрхийн эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг тавдугаар, сувиллыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны "Шалгуур үзүүлэлт батлах тухай" 395 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.УДВАЛ

080010

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 07 сарын 08 өдрийн
07 тоот тушаалын 1 дүгээр
хавсралт

ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ, БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМНЭЛГИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БҮЛЭГ 1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт

№	Үнэлгээ өгөх чиглэл	Шалгуур үзүүлэлт		Үнэлгээ	
				Байгууллага	Шинжээч
1.	Байгууллагын удирдлага, манлайлал	1.1.	Үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэл бүрийн дагуу тасаг, нэгжийг зохион байгуулсан байх		
		1.2.	Ажлын байрны тодорхойлолтыг ажилтан бүрээр гарган баталгаажуулж, ажилтнуудыг байршуулсан байх		
		1.3.	Байгууллага нь судалгаа, харьцуулсан үнэлгээнүүдэд үндэслэсэн хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй байх		
		1.4.	Эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ өгдөг, урамшуулал, хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байх		
		1.5.	Болзошгүй гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх төлөвлөгөөтэй, жил бүр тодотгол хийдэг байх		
		1.6.	Байгууллага нь тусламж үйлчилгээний стандарт, удирдамж, эрх зүйн баримт бичгээр эрүүл мэндийн ажилтнуудыг хангасан, сургалт хийдэг байх		
		1.7.	Дотоод хяналтын нэгж, ажилтанг ажиллуулж, хяналтыг тогтмолжуулсан байх		
		1.8.	Ажил үйлчилгээг сайжруулахаар гаргасан тушаал шийдвэрийн хувь 50%-иас дээш байх		
		1.9.	Санхүүгийн хяналт, шалгалтад хамрагдсан, зөрчилгүй ажилласан байх		
		1.10.	Удирдах зөвлөлтэй, улирал тутам хуралдаж, байгууллагын үйл ажиллагаанд дүгнэлт өгдөг байх		
		1.11.	Ёс зүйн салбар хороотой, үйл ажиллагаа тогтмолжсон байх		
		1.12.	Настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ээлтэй орчин бүрдүүлсэн байх		

2.	Хүний нөөцийн удирдлага	2.1.	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, /төлөвлөгөө/-тэй байх	
		2.2.	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн 20-иос доошгүй хувь нь эрдмийн болон мэргэжлийн зэрэгтэй байх	
		2.3.	Тухайн байгууллагад ажиллаж буй эмч эмнэлгийн мэргэжилтнүүд нь төрөлжсөн мэргэжил эзэмшиж, мэргэшсэн байх	
		2.4.	Шинээр ажиллуулах эмнэлгийн мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулалтаар авдаг байх	
		2.5.	Эрүүл мэндийн ажилтнууд ёс зүйн сургалтанд хамрагдсан байх	
		2.6.	Шинэ ажилтанг сургаж, дадлагажуулдаг байх	
		2.7.	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байх	
3.	Тусламж үйлчилгээний чанарын удирдлага	3.1.	Тогтмол үйл ажиллагаатай чанарын алба, багтай, төлөвлөгөөтэй байх	
		3.2.	Байгууллага нь чанарын үзүүлэлтийг гаргаж, мөрдүүлсэн, түүнд нь ахиц гарсан байх	
		3.3.	Эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүр чанарын сургалтанд хамруулсан байх	
		3.4.	Чанар сайжруулах дэвшилтэт аргуудыг нэвтрүүлсэн, үр дүнг тооцсон байх	
		3.5	Байгууллага нь ажилтан бүрээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.6	Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.7	Үйлчлүүлэгчдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байх	
4.	Мэдээллийн удирдлага	4.1.	Байгууллага нь үйл ажиллагааны үзүүлэлтүүд болон хүний нөөц, санхүү, багаж тоног төхөөрөмж, эмийн мэдээллээр сүүлийн 5 жилээс доошгүй хугацааны мэдээний санг үүсгэж, тогтмол баяжуулж, ашигладаг байх	
		4.2.	Байгууллага нь үйл ажиллагааг нэгтгэсэн цахим сүлжээг бий болгож, гадаад, дотоод сүлжээнд холбогдсон, үйл ажиллагаа нь тогтмолжсон, ажилтнууд мэдээллийн сүлжээг ашигладаг байх	
		4.3.	Байгууллага нь цахим хуудасны үйл ажиллагаа тогтмолжсон байх	
		4.4.	Зайн анагаах ухааны сүлжээг үе шаттайгаар өргөжүүлж, зайнаас эмнэлзүйн зөвлөгөө өгдөг байх	
		4.5.	Цахим мэдээллийн нууцыг хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх	
5.	Аюулгүй байдал, эрсдлийн удирдлага	5.1.	Аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын багтай, төлөвлөгөөтэй ажилладаг байх	
		5.2.	Байгууллага нь аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээг тогтмол хийдэг байх	
		5.3.	Алдаа зөрчлийг бүртгэж, мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх	

		5.4.	Эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьдаг байх	
		5.5.	Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгч нарт дэмжлэг үзүүлэх журам боловсруулан мөрддөг байх	
6.	Байгууллагын соёл, маркетинг	6.1	Байгууллага нь үйлчилгээний соёлыг төлөвшүүлсэн байх	
		6.2	Байгууллага нь маркетингийн үйл ажиллагааны судалгаатай, сурталчилгаа хийдэг байх	
7.	Байгууллагын ил тод байдал	7.1.	Удирдлагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан байх	
		7.2.	Төсөв санхүүгийн, хүний нөөцийн, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажилладаг байх	
		7.3.	Төлбөртэй тусламж үйлчилгээний журам, жагсаалт гаргаж, мөрдөж ажилласан байх	

БҮЛЭГ 2. Тусламж үйлчилгээний технологийн мөрдөлт

№	Үнэлгээ өгөх чиглэл	Шалгуур үзүүлэлт		Үнэлгээ	
				Байгууллага	Шинжээч
I.Нийтлэг шалгуур үзүүлэлтүүд					
а. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ					
1.	Эрүүл мэндийн боловсрол олгох	1.1.	Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалтын хөтөлбөр /төлөвлөгөө/-тэй, сургалт явуулдаг байх		
		1.2.	Үйлчлүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөлөөр хангагдсан байх		
		1.3.	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлсэн байх		
2.	Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт	2.1.	Эрүүл мэндийн үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс өөрийн байгууллагад хамаарах үйл ажиллагааг төлөвлөн ажилладаг байх		
		2.2.	Хөтөлбөр бүрийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж ажилладаг байх		
		2.3.	Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж үр дүнг тооцсон байх		
		2.4	Үйлчлүүлэгчдийн эрүүл насжилтыг дэмжих сургалт, сурталчилгаа явуулдаг байх		
б.Амбулаторын тусламж үйлчилгээ					
3.	Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ	3.1.	Лавлагаа мэдээллийн хөтөч, лавлагаа өгөх цэг ажиллуулдаг байх		
		3.2.	Товлолт үйлчилгээний шинэ дэвшилтэт, үр дүнтэй арга нэвтрүүлсэн байх		

		3.3.	Хүлээлгийн танхимуудад үйлчилүүлэгчид тав тухтай орчин бүрдүүлж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авдаг байх	
4.	Үзлэг, оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө	4.1.	Батлагдсан бүтцийн дагуу амбулаторын үзлэгийн өрөөнүүдийг зохион байгуулж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан байх	
		4.2.	Үзлэгийн кабинетууд нь батлагдсан норматив тохирсон ачаалалтай, оношилгоо, эмчилгээний талаар үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчилдэг, зөвлөгөө өгдөг байх	
5.	Амбулаторын эмчилгээ	5.1.	Амбулаториор хийгдэх үйлдлийн жагсаалт батлагдсан байх	
		5.2.	Өдрийн эмчилгээний өрөөтэй, багаж төхөөрөмж, эмнэлгийн мэргэжилтнээр хангасан, ая тухтай орчинд үйлчилгээ үзүүлдэг байх	
6.	Эрүүл мэндийн идэвхтэй хяналт	6.1.	Үзлэгийн кабинетууд үйлчлүүлэгчид илэрсэн өвчин эмгэгийг бүртгэн авч идэвхитэй хяналтанд эмчлэн эрүүлжүүлэх талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай уялдаатай ажилладаг байх	
		6.2.	Идэвхтэй хяналтын үр дүнг тооцдог байх	
в. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ				
7.	Яаралтай тусламж үйлчилгээ	7.1	Яаралтай тусламжийн тасаг /нэгж/ -ийг зохион байгуулж, орон тоогоор бүрэн ажилладаг байх	
		7.2	Үйлчлүүлэгчдийг хүлээн авах журамтай, мөрдөж ажилладаг байх	
		7.3	Яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангагдсан байх	
		7.4	Эрэмбэлэн ангилах зарчмын дагуу үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгч, тусламж үйлчилгээг шуурхай, багаар үзүүлдэг байх	
		7.5	Яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх дуудлагын системтэй байх	
		7.6	Дүрс оношилгоо, лабораторийн шинжилгээг 24 цагаар хийдэг байх	
8.	Эмчилгээ, оношилгоо, технологи эзэмшилт	8.1	Оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж, стандартыг мөрддөг байх	
		8.2	Түгээмэл үйлдлийн технологийг эзэмшсэн байх	
9.	Ажилбар, тарианы өрөөний үйл ажиллагаа	9.1	Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан ажилбар болон тарианы өрөөтэй байх	
		9.2	Ажилбар, тарианы технологийн мөрдөлтөд графикийн дагуу хяналт, үнэлгээ хийдэг байх	

II. Өвөрмөц шалгуур үзүүлэлтүүд			
Мэс заслын тусламж үйлчилгээ			
10.	Өдрийн мэс засал	10.1 Өдрийн мэс засал хийх шаардлага хангасан өрөө, багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	
		10.2 Өдрийн мэс заслын эмчилгээний батлагдсан жагсаалттай, түүний дагуу мэс засал хийгдсэн, үр дүнг тооцсон байх	
		10.3 Шаардлага хангасан боолтын өрөөтэй байх	
11.	Тусламж үйлчилгээний технологи	11.1 Өөрийн байгууллагад хийгдэх мэс засал ба ажилбарын жагсаалт гарсан, түүнийг мэргэжилтнүүд нь бүрэн эзэмшсэн байх	
		11.2 Төлөвлөгөөт мэс засал хийх хуваарийг урьдчилан баталдаг, бэлтгэлийг хангадаг байх	
		11.3 Мэс заслын явцад болон дараа гарсан хүндрэлийг бүртгэдэг, түүнээс сэргийлэх ажил зохион байгуулдаг байх	
		11.4 Эд, эсийн шинжилгээ хийдэг, шинжилгээний дүгнэлтийг үйлчлүүлэгчид мэдээлдэг байх	
12.	Өвчтөний аюулгүй байдал	12.1 Өвчтөн, тэдний гэр бүлийнхэнд хийгдэх мэс заслын талаар танилцуулж, мэс засал хийлгэх зөвшөөрөл авч баталгаажуулсан байх	
		12.2 Мэс заслын хяналтын хуудас хөтөлдөг, үр дүнг тооцдог байх	
		12.3 Мэс заслын өрөөг камержуулсан байх	
		12.4 Хагалгааны өрөөнд цахилгааны ба хийн нөөц үүсгүүртэй байх	
Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тусламж үйлчилгээ			
13.	Эрчимт эмчилгээ	13.1 Үйл ажиллагааны зохицуулгатай ортой, хүрэлцэхүйц орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглосон, аюулгүй найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх	
		13.2 Өвчтөний ор бүрийг амин чухал эрхтэнийг дэмжих тоног төхөөрөмжөөр хангасан, тэдгээрийн бэлэн байдлыг хянадаг байх	
		13.3 Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гаргаж, бэлэн байдлыг хангасан байх	
		13.4 Үйлчлүүлэгчийг заалтын дагуу эрчимт эмчилгээний тасаг/өрөөнд хүлээн авч амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу, багаар үзүүлдэг байх	
		13.5 Үйлчлүүлэгчийн биеийн байдал, хийгдсэн эмчилгээний тухай мэдээллийг гэр бүлийнхэнд нь шуурхай мэдээлдэг байх	
14.	Мэдээгүйжүүлгийн тусламж үйлчилгээ	14.1 Мэдээгүйжүүлэг хийх заалтын дагуу бэлтгэл хангаж, мэдээгүйжүүлэг хийхийн өмнө аппарат, багажийг шалгаж тэмдэглэл хөтөлж хэвшсэн байх	

		14.2	Мэдээгүйжүүлэг хийх, түүний эрсдлийн талаар үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлийнхэнтэй ярилцсан, тэмдэглэл хөтөлсөн байх	
		14.3	Мэдээгүйжүүлгийг стандарт, удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
15.	Түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдал	15.1	Түргэн тусламж үйлчилгээний журам, дуудлагаар ажиллах эмнэлгийн мэргэжилтний хуваарийг баталж, мөрддөг байх	
		15.2	Дуудлагын бүртгэл хөтөлдөг, үр дүнг нь тооцдог байх	
		15.3	Тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, багаж, хэрэгслээр бүрэн хангагдсан, жагсаалт, бүртгэлтэй байх	
		15.4	Тусламж үзүүлэхэд шаардлагатай автомашин, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, дохиолол, дуудлагын системийг байрлуулсан байх	
Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ				
16.	Тусламж үйлчилгээний технолги	16.1	Төрлөг удирдах үйл ажиллагааг стандарт, удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
		16.2	Төрөх өрөөнд нэн шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байх	
		16.3	Төрсний дараах эхний 1 цагт эрүүл нярайг амлуулдаг ажил тогтмолжсон байх	
		16.4	Төрсний дараа эх, нярайд тавих хяналтыг зөв зохион байгуулсан байх	
		16.5	Төрсөн эхийг гарахад нь холбогдох мэдээллийг харъяа өрхийн эмнэлэгт нь хүлээлгэн өгдөг байх	
		16.6	Перинаталь оношилгоо, эмчилгээнд орчин үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж, лабораторийн чадавхийг сайжруулсан байх	
		16.7	Эмэгтэйчүүдийн өвчний оношилгоо, эмчилгээг стандарт, удирдамжийн дагуу хийж, үр дүнг тооцдог байх	
Сувилахуйн тусламж үйлчилгээ				
17.	Тусламж үйлчилгээний зохион байгуулалт	17.1	Сувилахуйн албатай, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх	
		17.2	Сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй, хэрэгжүүлсэн байх	
		17.3	Сувилахуйн дадлага, сургалтыг явуулах өрөө, тоног төхөөрөмжтэй, сургалтыг тогтмол явуулдаг, бүртгэл судалгаатай байх	
		17.4	Асаргаа, сувилгаанд шинэ технологи, чанар сайжруулах аргуудыг ашиглаж, үр дүнг тооцсон байх	
18.	Тусламж үйлчилгээний технологи	18.1	Сувилахуйн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийг мөрдөж ажилладаг байх	

		18.2	Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр боловсруулсан аргачлал, удирдамжтай, мөрддөг байх	
		18.3	Сувилахуйн тусламжийг 5 шатлалын дагуу үзүүлдэг, ажлын чанар үр дүнг тооцож ажилласан байх	
		18.4	Сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлэг хийж, үр дүнг тооцдог байх	
Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ				
19.	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ	19.1	Үйлчлүүлэгч болон ажилтнуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг байх	
		19.2	Үйлчлүүлэгч, ажилтнуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх	
		19.3	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчид стандарт, удирдамжийн дагуу тусламж үйлчилгээ үзүүлдэг байх	
		19.4	Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангасан /байр, өрөө, цонх шат, хамгаалалт, бусад/ байх	
		19.5	Нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнийг тусгаарлах арга хэрэглэх	
		19.6	Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дахь сэтгэц нөлөөт эмээр хангагдсан байх	
20.	Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ	20.1	Нийгэм хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээг үзүүлсэн байх	
		20.2	Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээний хэрэгслээр хангагдсан байх	
Сэргээн засах тусламж үйлчилгээ				
21.	Тусламж үйлчилгээний зохион байгуулалт	21.1	Сэргээн засах тусламж, үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
		21.2	Сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрлийн жагсаалт гаргасан, түүнийг хэрэгжүүлсэн байх	
		21.3	Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан байх	
		21.4	Эмчилгээний үр дүнг тооцсон судалгаатай байх	
Уламжлалт анагаах ухаан (УАУ)-ы тусламж үйлчилгээ				
22.	Тусламж үйлчилгээний зохион байгуулалт	22.1	Тусламж, үйлчилгээний стандарт, удирдамжаар эмнэлгийн мэргэжилтнийг хангасан байх	
		22.2	Үзүүлж буй тусламж үйлчилгээнд шаардагдах багаж, тоног төхөөрөмжтэй байх	
		22.3	Өөрийн үзүүлэх тусламж үйлчилгээний хүрээнд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний тайлангийн маягтаар статистик, тайлан мэдээг гаргаж тайлагнадаг байх	

23.	УАУ-ны үндсэн суурь өвчний үеийн тусламж үйлчилгээ	23.1	Хий, шар, бадган, хурмал, цус, шар ус, хорхой өвчнийг УАУ-ны оношийн ангиллын дагуу оношилж, эмчилгээг стандарт, удирдамжийн дагуу хийдэг байх	
		23.2	Хий, шар, бадган, хурмал, цус, шар ус, хорхой өвчний үеийн идээ ундаа, явдал мөр болон эм, заслын эмчилгээг стандарт, удирдамжийн дагуу хийдэг байх	
24.	Уламжлалт дотор өвчний үеийн тусламж үйлчилгээ	24.1	Эс шингэсэн, хаван, бэтэг, их архаг өвчин, хэсэг бусаг өвчин, цул, сав эрхтний өвчний УАУ-ны оношийн ангиллын дагуу оношлож оношилж, эмчилгээг стандарт, удирдамжийн дагуу хийдэг байх	
25.	Уламжлалт халуун өвчний үеийн тусламж үйлчилгээ	25.1	Халуун өвчний оношилгоо, эмчилгээг стандарт, удирдамжийн дагуу хийдэг байх	
26.	УАУ-ны бусад эмгэгийн үеийн (эмэгтэйчүүд, настан, хүчжүүлэх зэрэг) тусламж үйлчилгээ	26.1	УАУ-ны бусад эмгэгийн үеийн тусламж үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу хийж гүйцэтгэдэг байх	
27.	Эмийн зохистой хэрэглээ	27.1	Уламжлалт эмийн зохистой хэрэглээг тухайн эмгэгийн эмнэлзүйн удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн байх	
		27.2	Эмийн гаж нөлөөний бүртгэл, судалгаатай байх	
		27.3	Уламжлалт анагаах ухааны эмийг жороор бичдэг байх	
Эмчилгээний хоолны үйлчилгээ				
28.	Тусламж үйлчилгээний зохион байгуулалт	28.1	Хоолны эмч, мэргэжилтнийг ажиллуулдаг байх	
		28.2	Тасаг, нэгжид хэвтэн эмчлүүлэгчид хооллох тав тухтай орчин бүрдүүлсэн байх	
29.	Хоолны технологи, норм	29.1	Үйлчлүүлэгчдэд зориулсан эмчилгээний хоолны цэс боловсруулж баталсан, хоолыг технологи, аргачлалын дагуу хийдэг байх	
		29.2	Үйлчлүүлэгчдэд олгож байгаа хоолны илчлэг, орц, нормыг тооцдог байх	
		29.3	Эмчилгээний хоолны аюулгүй байдлыг хангаж, зохих журмын дагуу бэлтгэн хүргэдэг байх	
		29.4	Хүнд, хүндэвтэр өвчтөнийг хооллоход зориулсан хоолны хэрэгслээр хангасан байх	
Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ (тасаг тус бүрийг үнэлнэ)				
30.	Тусламж үйлчилгээний зохион байгуулалт	30.1	Үзүүлж буй тусламж үйлчилгээний стандарт,удирдамжийн жагсаалт гаргасан, мэргэжилтнүүдийг гарын авлагаар хангасан байх	
		30.2	Үзүүлж буй тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	
		30.3	Үзүүлж буй тусламж үйлчилгээний технологийг бүрэн эзэмшсэн байх	

Лавлагаа тусламж үйлчилгээ (Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд хамаарна)				
31.	Удирдлага, зохион байгуулалт	31.1	Тусламж үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтыг хийж, баталгаажуулсан байх	
32.	Тусламж үйлчилгээний технологи	32.1	Үзүүлэх лавлагаа тусламж үйлчилгээг бүрэн үзүүлдэг байх	
		32.2	Үзүүлж буй тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийг мөрдөж ажилладаг байх	
		32.3	Үзүүлж буй тусламж үйлчилгээний технологийг бүрэн эзэмшсэн байх	
33.	Мэргэжил арга зүйн удирдлага	33.1	Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг байх	
		33.2	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж, мэргэшүүлсэн байх	
		33.3	Тухайн мэргэжлийн чиглэлээр оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал боловсруулсан байх	
		33.4	Хүн амын өвчлөл, өвчний тархалт, нас баралтыг тандан судалдаг байх	
Хавдраас сэргийлэх				
34.	Хорт хавдраас сэргийлэх үйл ажиллагаа	34.1	Хүн амын дунд хавдрын зонхилох хүчин зүйлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, улсын хэмжээнд жил бүр зохиох ажлын график төлөвлөгөөтэй, хэрэгжүүлж ажилладаг, үр дүнг тооцсон байх	
		34.2	Жилд 3-аас доошгүй аймагт үзлэгийн багийг ажиллуулж, хорт хавдрыг эрт илрүүлэх, сэргийлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх	
		34.3	Аймаг, хотын нэгдсэн болон дүүргийнэмнэлгүүдээр эрт илрүүлгийн удирдамж, төлөвлөгөө боловсруулан мөрдүүлж, биелэлтэнд нь хяналт тавьсан байх	
		34.4	Жил бүр сонгож авсан аймаг, нийслэлийннэгдсэн болон дүүргийн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хорт хавдраас сэргийлэх талаар авч явуулж буй үйл ажиллагаанд үнэлгээ хийж, зөвлөмж өгч, мэдээлдэг байх	
		34.5	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн үзүүлж буй тусламжийн хүрээнд хорт хавдрын мэс засал хийсэн тохиолдолд туяа болон хими эмчилгээний зөвлөх мэргэжилтнүүдтэй зөвлөдөг тогтолцоонд шилжүүлсэн, түүнд тавих хяналтыг бий болгосон байх	
		34.6	Умайн хүзүү, хөхний хавдрын эрт илрүүлгийн бүртгэл хяналт, эргэн дуудах тогтолцооны мэдээллийн сантай байх	

35.	Туяа эмчилгээ	35.1	Үзүүлж буй тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн жагсаалт гаргасан, мэргэжилтнүүдийг гарын авлагаар хангасан байх	
		35.2	Туяа эмчилгээнд ажиллах эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэсэн байх	
		35.3	Туяа эмчилгээнд шаардагдах аппарат, үүсвэрүүд болон орчин үеийн эмчилгээний аргуудыг нэвтрүүлсэн байх	
		35.4	Туяа эмчилгээний дараа туяанаас хамгаалах, хордлого тайлах зэрэг эмчилгээ хийх стандарт болон өвчтөний аюулгүй байдлын стандартыг боловсруулан түүнд шаардагдах зүйлээр хангаж хэрэгжүүлсэн байх	
		35.5	Туяа эмчилгээний чанар үр дүнг тооцож ажилладаг байх	
36.	Хими эмчилгээ	36.1	Үзүүлж буй тусламж, үйлчилгээний стандарт, удирдамжийн жагсаалт гаргасан, мэргэжилтнүүдийг гарын авлагаар хангасан байх	
		36.2	Хими эмчилгээнд хэрэглэх орчин үеийн эмүүдийн жагсаалт гаргасан байх	
		36.3	Жагсаалтын дагуу хангалт хийгдсэн, эмчилгээний стандарт боловсрогдсон байх	
		36.4	Хими эмчилгээ хийх мэргэжилтнүүдийг сургаж, бэлтгэдэг байх	
		36.5	Хими эмчилгээний өдрийн эмчилгээний байр, тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр хангагдаж, үйл ажиллагаа зохих ёсоор хийгдсэн байх	
37.	Мэс залын эмчилгээ	37.1	Тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлдэг, чанар үр дүнг тооцож ажилладаг байх	
		37.2	Мэс засал хийлгэсэн өвчтөн 5-аас дээш жил амьдарсан, энэ талаар судалгаатай байх	
38.	Хөнгөвчлөх эмчилгээ	38.1	Тусламж үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
		38.2	Орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	
Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ				
39.	Мэргэжил арга зүйн удирдлага	39.1	Эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө, удирдамж, журам, заавар боловсруулан өгч хяналт тавьж ажилладаг байх	
		39.2	Нөхөн үржихүй, эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний хэмжээнд сургалтууд зохион байгуулсан байх	
		39.3	Нөхөн үржихүй, эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр хяналт- шинжилгээ, судалгаа хийсэн байх	
		39.4	Судалгаа, үнэлгээний зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан байх	

40.	Хүүхдийн эрүүл мэнд	40.1	Перинаталь оношилгоо, эмчилгээнд орчин үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж, лабораторын чадавхийг сайжруулсан байх	
		40.2	Перинаталь нас баралтыг бууруулсан байх	
		40.3	Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх	
		40.4	Хүүхдийн шүдний кариес, гүйлсэн булчирхайн үрэвсэл, дунд чихний үрэвсэл зэргийг жил бүр эмчлэн эрүүлжүүлж үр дүнг тооцсон байх	
41.	Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд	41.1	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэг, архаг өвчнийг илрүүлж, эрүүлжүүлэх талаар тодорхой ажил зохиосон байх	
		41.2	Нөхөн үржихүйн эрүүл мэндэд андрологийн тусламж, үйлчилгээг бий болгож, чадавхийг нэмэгдүүлсэн байх	
		41.3	Үргүйдлийг оношилох, эмчлэх аргуудыг нэвтрүүлсэн байх	
		41.4	Цэвэршилтийн үеийн эмчилгээ, оношлогооныр дүнг тооцсон байх	
		41.5	Охидын тусламж үйлчилгээг үзүүлдэг, судалгаатай байх	
		41.5	Үр шилжүүлэн суулгах лабораторийг (IVF) байгуулж, техник, тоног төхөөрөмжөөр хангаж, эмч мэргэжилтнийг нь сургаж мэргэшүүлсэн байх	
		41.6	Удамзүйн шинжилгээний, цитогенетикийн оношилгооны лабораториудыг байгуулсан байх	
		41.7	Үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөөг сайжруулж, аюултай үр хөндөлтөөс сэргийлэх, давтан үр хөндөлтийг бууруулах чиглэлээр сурталчилгааг өргөн зохион байгуулсан байх	
Халдварт өвчнөөс сэргийлэх				
42.	Мэргэжил арга зүйн удирдлага	42.1	Халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний тандалтын тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх талаар мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангасан байх	
		42.2	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг хүн амд олгох талаар тодорхой ажил зохиосон байх	
		42.3	Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, цартахлын үед шаардагдах эм, урвалж бодис, оношлуур, вакцин, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, эмнэлгийн багаж, хэрэгсэл, сорьц цуглуулах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлсэн байдалд хяналт, судалгаатай байх	

		42.4	Бүх халдварт өвчнийг илрүүлэх лабораторийн хүчин чадал, тоног төхөөрөмж, урвалж бодис, хүн хүчин, чадавх бүрдсэн, чанарт тавих гадаад, дотоод хяналтыг бэхжүүлж, лабораторийнн оношилгооны үнэн бодит байдлыг сайжруулах талаар ажил зохиосон байх	
		42.5	Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), томуу, улаанбурхны лабораторийг олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамруулсан байх	
		42.6	Лабораторийн нэгдсэн сүлжээ байгуулагдсан байх	
		42.7	Алс дорнодын хачгаар дамжих энцефалит, ханта, япон энцефалит, өрнөд нилийн халуурал, өвчний вирусийг өсгөвөрлөх шинжилгээ болон бабезиоз, криптоспоридиоз өвчнийг оношлох лабораторийн арга нэвтэрсэн байх	
43.	Сүрьеэгийн тусламж, үйлчилгээ	43.1	Хүн амын дундах сүрьеэгийн тархалтын түвшин тогтоох судалгаа хийсэн байх	
		43.2	Сүрьеэгийн эмийн даслын тандалт судалгаа хийсэн байх	
		43.3	Өсгөвөрлөх шинжилгээний нэгжийг өвчлөл өндөртэй аймаг болон бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд байгуулсан байх	
		43.4	Улсын нэгдсэн эмнэлгүүдийн лабораторийг түрхэцийн чанарын хяналтын тогтолцоонд хамруулсан байх	
		43.5	Эд эсийн, түрхэцийн шинжилгээний лаборатори байгуулагдсан болон молекул биологийн аргыг шинжилгээнд ашигладаг болсон байх	
		43.6	Эмэнд дасалтай нь батлагдсан, эмчилгээ хүлээгдэж байгаа өвчтөний хавьтлын болон халдвар хяналтын судалгаа хийсэн байх	
Сэтгэцийн эрүүл мэнд				
44.	Мэргэжил арга зүйн удирдлага	44.1	Байгууллагуудыг сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангадаг байх	
		44.2	Сэтгэцийн эрүүл мэндийн талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг явуулсан байх	
		44.3	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нийгэм, хамт олны дунд зохион байгуулах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, загвар төсөл хэрэгжүүлсэн байх	
		44.4	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийг хөнгөвчлөхөд чиглэсэн оношилгоо, эмчилгээний бүдүүвч боловсруулан гаргаж сум, өрхийн эмнэлгийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх	
		44.5	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаар зайны сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалтын материал гаргаж сургалт явуулсан байх	

		44.6	Сум, өрхийн эмнэлгээр үзүүлж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байдалд үнэлгээ хийж, авах арга хэмжээг төлөвлөсөн байх	
		44.7	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг аймаг, дүүргийн эмнэлэгтэй холбосон цахим сүлжээтэй болгосон байх	
45.	Сэтгэцэд нөлөөт эмийн хангалт	45.1	Сэтгэцэд нөлөөт эмийн хангамжийгсайжруулах, сэтгэцэд нөлөөт шинэ эмийг эмчилгээ, үйлчилгээнд нэвтрүүлсэн байх	
		45.2	Сэтгэц нөлөөт үнэгүй эмээр хангагдсан байх	
Осол гэмтлээс сэргийлэх				
46.	Мэргэжил арга зүйн удирдлага	46.1	Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүтэц, зохион байгуулалт оновчтой болсон байх	
		46.2	Осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангадаг байх	
		46.3	Зам тээврийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, хандлагыг өөрчлөн зохистой зан үйлийг төлөвшүүлэх, чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлсэн байх	
		46.4	Хүүхдийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, амьдрах, сурах, хөдөлмөрлөх аюулгүй орчин бүрдүүлэх, эрүүл аж төрөх ёс, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлсэн байх	
		46.5	Осол гэмтэл, хүчирхийлэлд өртөгсдөд нийгэм, хамт олонд суурилсан нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар холбогдох байгууллагын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлсэн байх	
		46.6	Хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх чиглэлээр эмнэлэгт түшиглэсэн "нэг цэгийн үйлчилгээ"-ний төвийн үйл ажиллагааг сайжруулж, чанар, хүртээмжийг дээшлүүлсэн байх	
Халдварт бус өвчинтэй тэмцэх, сэргийлэх				
47.	Мэргэжил арга зүйн удирдлага	47.1	Байгууллагуудыг халдварт бус өвчнөөс сэргийлэх болон эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангадаг байх	
		47.2	Оношилгоо, эмчилгээний удирдамж, стандартын дагуу зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх, оношлох, хянах ажлыг зохион байгуулсан байх	
		47.3	ХБӨ-ий оношилгоо, эмчилгээнд шаардлагатай багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх	

		47.4	Зонхилон тохиолдох ХБӨ-ий үед үзүүлэх эмнэл зүйн тусламж, үйлчилгээний дотор урьдчилан сэргийлэх арга хэмжээний эзлэх хувийн жинг нэмэгдүүлсэн байх	
		47.5	Цусны (артерийн) даралт, цусан дахь саахар, шээсэн дэх натрийн давсны хэмжээ, биеийн жин зэрэг ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийг иргэд өөрсдөө хянах дадал хэвшилтэй болгох МСС явуулдаг байх	
		47.6	Зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг тандах, оношлох, зөвлөгөө өгөх, сургалт явуулах, хянах теле-анагаахын тогтолцоог өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	
		47.7	Архи, тамхинаас гаргах, илүүдэл жинг бууруулах, таргалалтын хам шалтгааныг тодорхойлон эмчлэх зэрэг ХБӨ-өөр өвчлөх эрсдэл бүхий болон өвчтэй хүн амын дунд эрсдэлийн түвшинг бууруулах, хүндрэлээс сэргийлэхэд чиглэсэн ажлыг эрчимжүүлсэн байх	
г.Параклиникийн тусламж үйлчилгээ				
Лабораторийн болон бусад шинжилгээ				
48.	Лабораторийн зохион байгуулалт	48.1	Лабораторийг стандартад тавигдах шаардлага, үйл ажиллагааны дагуу зохион байгуулсан байх	
		48.2	Мэргэжлийн хүний нөөцөөр бүрэн хангаж, ур чадварыг тогтмол дээшлүүлдэг байх	
49.	Багаж тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт	49.1	Лабораторит байвал зохих тоног төхөөрөмж нь батлагдсан жагсаалтын дагуу байх	
		49.2	Лабораторийн багаж бүрэн ажилладаг, хүчин чадлыг бүрэн ашигладаг байх	
		49.3	Лабораторийн тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг, засвар үйлчилгээ тохируулгыг тогтмол хийдэг байх	
50.	Урвалж, бодисын хангалт, аюулгүй байдал	50.1	Лабораторит шаардлагатай урвалж, бодисоор бүрэн хангагдсан, хүрэлцээтэй нөөцтэй байх	
		50.2	Оношлуур, урвалж, бодисын чанарын баталгаа, шинжилгээнд хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааг хангасан байх	
		50.3	Үйлчлүүлэгчдээс шинжилгээ авах хуваарийн дагуу ажилладаг байх	
51.	Шинжилгээний чанарын баталгаажилт, хяналт	51.1	Лабораторийн шинжилгээний гадаад, дотоод хяналтыг тогтмол хийдэг байх	
		51.2	Лабораторийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдсан байх	
52.	Бусад шинжилгээ, оношилгоо	52.1	Дүрс оношилгооны нэгж/ хэсгийг стандартад тавигдах шаардлага, үйл ажиллагааны дагуу зохион байгуулж, мэргэжилтнээр хангасан байх	
		52.2	Рентген туяагаар үйлчилгээ үзүүлэх үед туяаны хамгаалалтыг хийдэг, мөрддөг байх	

		52.3	Аюулгүй байдлыг хангах зорилгоор багаж, тоног төхөөрөмж, өрөө тасалгааг жил бүр бие даасан туяаны шинжээчээр үнэлүүлдэг эсэх	
		52.4	Дурангийн оношилгоо, эмчилгээг стандарт, удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
Эм зүй, эм судлал				
53.	Удирдлага, зохион байгуулалт	53.1	Эмийн санг стандартын дагуу зохион байгуулсан байх	
		53.2	Эмнэлэгт хэрэглэгдэх эмийн жагсаалтыг жил бүр гарган, хэрэгцээний /V-маш чухал, E-чухал, N- чухал бус/ зэрэглэлээр ангилдаг байх	
		53.3	Эмийн эмчилгээг зохицуулах хороо /ЭЭЗХ/ байгуулсан, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх	
54.	Эмийн хэрэглээ, хангалт, хадгалалт, зарцуулалт	54.1	Эмийн жорыг стандартын дагуу бичдэг байх	
		54.2	Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг Бүрдүүлж, хэрэглээ, хадгалалт, зарцуулалтад хяналт тавьдаг байх	
		54.3	Тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээний онцлогоос хамааран хэрэглэгдэх эмийн нөөцтэй, хэрэглээ, хадгалалт, зарцуулалтыг тооцдог байх	
		54.4	Онцгой байдлын нөхцөлд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгслийн нөөцтэй, хэрэглээ, хадгалалт, зарцуулалтыг тооцдог байх	
		54.5	Эм бэлтгэх, түгээх үйл ажиллагаа журмын дагуу хийгддэг байх	
		54.6	Эм эмнэлгийн хэрэгслийн хангалт, хэрэглээтэй холбоотой судалгааг хийж, үйл ажиллагаандаа ашигладаг байх	
55.	Эмийн чанарын баталгаажилт	55.1	Эм эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, аюулгүй байдалд дотоодын хяналт хийдэг байх	
56.	Эмийн зохистой хэрэглээ	56.1	Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ТСТ /тандалт, сургалт, төлөвлөлт/-ийн аргыг нэвтрүүлж, үр дүнг тооцож ажилладаг байх	
		56.2	Иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх "СВИА" – сургалт явуулдаг байх	
		56.3	Эмийн гаж нөлөөний бүртгэл судалгаа хийгдсэн, эргэн мэдээлдэг, үнэлдэг байх	
Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ				
а.ЦЦБ-ний үйлдвэрлэл явуулдаг цусны салбар банктай эмнэлгийг үнэлнэ.				
57.	Цусны салбар банкийг үйл ажиллагаа	57.1	Цусны салбар банкийг стандартын дагуу зохион байгуулсан байх	
		57.2	Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг хангасан байр, өрөөтэй, мэргэжилтнээр хангагдсан байх	
		57.3	Цусны алба, салбар банкны эмч, тусгай мэргэжилтнийг сургаж мэргэшүүлсэн, ур чадварыг дээшлүүлдэг байх	

		57.4	ЦЦБ үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, баталгаажсан байх	
		57.5	Донор сонгох, цусыг шинжлэх, бүтээгдэхүүний чанар шалгахад шаардлагатай оношлуур, урвалжаар хангагдсан, нөөцтэй байх	
		57.6	Салбар банк, сумдыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг байх	
58.	Донор бэлтгэх	58.1	ЦЦБ үйлдвэрлэх хүрэлцээтэй донорын нөөцтэй байх	
		58.2	Донорт үйлчлэх тав тухтай орчин бүрдүүлсэн байх	
		58.3	Донорууд шинжилгээгээр баталгаажсан байх	
59.	Лабораторийн шинжилгээ	59.1	Цуглуулсан цус, сийвэнгийн нэгж бүрд хийгдэх шинжилгээг бүрэн хийдэг байх	
		59.2	Шинжилгээний чанарын баталгаа хангаж ажилладаг байх	
		59.3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд хийгдэх чанарын шинжилгээг бүрэн хийсэн байх	
60.	Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	60.1	Эмнэлгийн захиалгын дагуу хүрэлцээтэй цус,цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олгодог байх	
		60.2	ЦЦБ-нийг зохих журмын дагуу хадгалж, зөв тээвэрлэдэг байх	
б. Цус сэлбэлт хийдэг бүх эмнэлгийг үнэлнэ.				
61.	Удирдлага, зохион байгуулалт	61.1	Цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлтэй,үйл ажиллагаа нь тогтмолжсон байх	
		61.2	Цусны асуудал хариуцсан их эмч, тусгай мэргэжилтэнг томилж, сургасан байх	
		61.3	ЦЦБ-ний хэрэглээ, хэрэгцээг тооцож ажилладаг байх	
		61.4	Цус сэлбэлтийн үйл ажиллагаа бүрт Тохирсон стандарт ажиллагааны аргачлал мөрддөг байх	
		61.5	ЦЦБ-ий зохистой хэрэглээний удирдамжийг мөрдөж ажилладаг байх	
62.	Тоног төхөөрөмж, оношлуурын хангалт	62.1	ЦЦБ тээвэрлэх зориулалтын сав, хадгалах хөргөгч, хөлдөөгчтэй байх	
		62.2	ЦЦБ сэлбэх зориулалтын систем хэрэглэдэг байх	
		62.3	Цусны бүлэг тодорхойлох таваг хэрэгслээр хангагдсан байх	
		62.4	Цусны АВО, резус бүлэг, хувийн тохироо тодорхойлох оношлуураар хангагдсан байх	
63.	Үйлчлүүлэг чийн аюулгүй байдал	63.1	ЦЦБ сэлбэх зөвшөөрөл авдаг байх	
		63.2	Цусны АВО, резус бүлэг, хувийн тохироог тодорхойлдог байх	
		63.3	ЦЦБ захиалах, сэлбэсэн протокол зэрэг анхан шатны маягтуудыг хөтөлдөг байх	

Эмгэг судлал				
64.	Үйл ажиллагааны зохион байгуулалт	64.1	Эмгэг судлалын албаны ажлын байр нь стандартын шаардлага хангасан,мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаар бүрэн хангагдсан байх байх	
		64.2	Эмгэг судлалын шинжилгээ хийх, цогцос задлан шинжлэх багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх	
		64.3	Эмнэлзүй эмгэг судлалын зөвлөгөөн хийж, түүний мөрөөр арга хэмжээ авдаг байх	
65.	Цогцос хадгалах, хүлээлгэн өгөх үйлчилгээ	65.1	Цогцос хадгалах, хүлээлцэх, ар гэрт нь хүлээлгэн өгөх журамтай, түүнийг мөрдөж ажилладаг байх	
		65.2	Цогцос хадгалах, шинжлэх өрөө тасалгаа, хөргөгч нь шаардлага хангасан байх	
		65.3	Гэр бүлийнхэн салах ёс гүйцэтгэх өрөөтэй байх	
66.	Лабораторийн шинжилгээ	66.1	Эмгэг судлалын шинжилгээг батлагдсан журмын дагуу бүрэн хийдэг байх	
		66.2	Мэс заслаар тайрагдсан эд эрхтэнийг устгах журмыг мөрдөж ажилладаг байх	
		66.3	Эд, эсийн шинжилгээ хийдэг байх	
		66.4	Оношлуур, урвалж бодисын чанарын баталгаа, шинжилгээнд хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааг хангасан байх	

БҮЛЭГ 3. Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ

№	Үнэлгээ өгөх чиглэл	Шалгуур үзүүлэлт		Үнэлгээ	
				Байгууллага	Шинжээч
3.1 Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт					
1.	Барилга, байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлага	1.1	Эрүүл ахуйн шаардлагын дагуу зөв зохион байгуулагдсан зориулалтын байртай, хэвтүүлэн эмчлэх болон үзлэгийн хэсэг нь тусдаа байх		
		1.2	Гадна талбай орчны стандартын шаардлага хангасан тохижилттой байх		
		1.3	Бүх өрөө байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалттай, мэс засал, лаборатори, ариутгал, гал тогоо зэрэг зарим өрөө нэмэлт агааржуулах системтэй байх		
2.	Халдвараас сэргийлэх үйл ажиллагаа	2.1	Халдварын сэргийлэлт, хяналт (ХСХ)-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй, хэрэгжүүлж ажилладаг байх		
		2.2	Үйл ажиллагааны онцлогт тохирсон ХСХ-ын журамтай, түүнийг эмнэлгийн ажилтнуудад танилцуулж мөрдөж ажилладаг байх		

		2.3	ХСХ-ын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг байгууллагын төсөв болон төсөл хөтөлбөрт оруулж шийдвэрлүүлдэг байх		
		2.4	ХСХ-ыг сайжруулах сайн туршлага, шинэ санааг нэвтрүүлж хэрэгжүүлдэг байх		
		2.5	Халдвараас сэргийлэх үйл ажиллагааг тогтсон хугацаанд хянаж, дүгнэдэг, үр дүн гарсан байх		
		2.6	Өрөө бүрт хэвийн ажиллагаатай, ажилбарын өрөөнүүд мэдрэгчтэй болон тохой хөлөөр ажилладаг угаалтууртай байх		
		2.7	Нянгийн эсрэг шингэн саван, спиртэнд суурьтай халдваргүйжүүлэх бодис, гарын цаасан алчуураар хангасан байх		
3.	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, хариу арга хэмжээ	3.1	Тандалт хийж эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ыг илрүүлсэн байх		
		3.2	ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг зохих журмын дагуу мэдээлж, хариу арга хэмжээг цаг алдалгүй авдаг байх		
		3.3	Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудад тандалт хийж шалгуур хуудас хөтөлдөг байх		
		3.4	ЭТҮХХ-ыг лабораториор баталгаажуулдаг байх, чанарын гадаад хяналтад хамрагддаг байх		
		3.5	Нянгийн тэсвэржилтийг байдалд тандалт, судалгаа хийдэг байх		
		3.6	Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээтэй, хэрэглээний журамтай байх		
		3.7	Үйлчлүүлэгчдийн дунд эмэнд тэсвэртэй нянгийн тандалтыг хийдэг байх		
4.	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах	4.1	Ажилтнуудыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-2 удаа зохион байгуулалттайгаар хамруулж, эмчлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ авдаг байх		
		4.2	Ажилтнуудын амрах, бие бялдрыг чийрэгжүүлэх боломж нөхцлөөр хангасан байх		
		4.3	Шинээр ажилд буй орж иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байх		
		4.4	Халдвар авах эрсдэлд хүчин зүйлд өртөлтийг бүртгэж, халдвараас сэргийлэх арга хэмжээг авсан байх		
		4.5	Тасаг, нэгж бүр өртөлтийн дараах сэргийлэлтийн иж бүрдлээр хангагдсан байх		
		4.6	Эрүүл мэндийн ажилтныг дүрэмт болон хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж, нөөцийг бүрдүүлсэн байх		

		4.7	Цусаар дамжих халдвартай эмнэлгийн ажилтны эрүүл мэндэд хяналт тавьж, ажил үүргээ гүйцэтгэх үед халдвар дамжуулах эрсдлээс сэргийлж заавар зөвлөмж өгдөг байх		
5.	Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгчгүйтгэл	5.1	Бохир, цэвэр, ариун хэсгээр тусгаарласан ариутгалын нэгдсэн тасагтай, ариутгалын журамтай, түүнийг мөрддөг байх		
		5.2	Ариутгалын тоног төхөөрөмжөөр хангагдсан, баталгаажилт хийлгэсэн байх		
		5.3	Ариутгалын үйл ажиллагаанд хяналт тавьж, баталгаажуулдаг байх		
		5.4	Улсын бүртгэлд бүртгэгдсэн, зөвшөөрөл, дүгнэлттэй чанарын шаардлага хангасан халдваргүйтгэлийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг байх		
		5.5	Ариутгалын үйл ажиллагаанд хөтлөгддөг анхан шатны маягтууд бүрэн хөтлөгдсөн байх		
		5.7	Дурангийн угаалга, халдваргүйжүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт хийгддэг зориулалтын машин, тэргэнцэр, шүүгээтэй байх		
		5.8	Ариун материалыг зөв хадгалж хэрэглэдэг байх		
		5.9	Зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлдэг байх		
		5.10	Шавж, мэрэгч устгал хийлгэдэг байх		
6.	Хог хаягдлын менежемент	6.1	Хог хаягдлыг зохих журмын дагуу ангилан ялгаж цуглуулдаг байх		
		6.2	Тээвэрлэх сав, тэргэнцэртэй, зөөвөрлөх маршрут, цагийг тогтоосон байх		
		6.3	Эрүүл ахуйн шаардлага хангасан түр хадгалах байртай, жин, тавиур зэрэг шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх		
		6.4	Устгалыг зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх эсвэл байгаль орчинд халгүй аргаар, зохих журмын дагуу устгадаг байх		
		6.5.	Хог хаягдлын таних тэмдэгтэй зориулалтын уут, саваар хангасан байх		
		6.6.	Эмнэлгээс гарч буй хог хаягдлын байдалд бүртгэл судалгаа хийж, бууруулах, менежментийг сайжруулах арга хэмжээ авдаг байх		
		6.7.	Нян судлалын лабораториос гарч байгаа тэжээлт орчин, өсгөвөр, сорьцын үлдэгдлийг халдваргүйжүүлдэг байх		
		6.8.	Хог хаягдлын байдлыг сар бүр нэгтгэж дүгнээд мэдээлдэг байх		
7.	Угаалга, цэвэрлэгээ	7.1	Тусдаа угаалгын газартай, урсгал нь зөв байх		
		7.2	Ангилан ялгаж угаах тоног төхөөрөмж, тээвэрлэх уут, сав, хадгалах тавиур, шүүгээтэй байх		

		7.3	Эмнэлгийн цагаан хэрэгсэл халдваргүйжүүлэх, угаах зориулалтын бодисоор хангагдсан байх		
		7.4	Эмнэлгийн орчныг эрсдлийн бүсээр ангилан, таних тэмдэгжүүлэн цэвэрлэгээний хуваарьтай, мөрдөж ажилладаг, хяналт тавьдаг байх		
		7.5	Цэвэрлэгээний материал бүхий тэргэнцэр, иж бүрдэлтэй, халдваргүйжүүлж хэрэглэдэг байх		
		7.6	Цэвэрлэгээний материалыг хадгалах цэгтэй байх		
8	Тусгаарлан сэргийлэлт	8.1	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах төлөвлөгөө, бэлэн байдлыг хангасан байх		
		8.2	Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үед хэрэглэгдэх тусгаарлах өрөөтэй байх		
		8.3	Тусгаарлах өрөө нь хувцас, багаж материал, эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан, нөөцтэй байх		
		8.4	Хамгаалах хувцас хэрэгслийг эрүүл мэндийн ажилтнууд зөв өмсөж, тайлж чаддаг байх		
		8.5	Тасаг, нэгжүүдэд халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлах нөхцлийг хангасан байх		
9.	Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлага, халдварын эсрэг дэглэм	9.1	Эрүүл ахуйн шаардлага хангасан агааржуулалт, гэрэлтүүлэгтэй, зөв зохион байгуулагдсан гал тогоотой байх		
		9.2	Хоол бэлтгэх, үйлдвэрлэх, хөргөх, хоолны хэрэгслийг угааж, хатаах багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх		
		9.3	Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд материал нь чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын дүгнэлттэй, баталгаажсан байх		
		9.4	Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангаж хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх		
		9.5	Хоол үйлдвэрлэлийн ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээг хийлгэсэн байх		
		9.6	Хоолны дээж авч, хадгалалтын хугацааг мөрддөг, устгалын бүртгэлтэй байх		
10.	Үйлчлүүлэгчдэд зориулсан өвөрмөц шаардлага	10.1	Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тоноглосон угаалтуур, суултууртай, байх		
		10.2	Эрүүл ахуйн шаардлага хангасан матрац, цагаан хэрэгслээр хангасан байх		
		10.3	Үйлчлүүлэгчдэд зориулсан угаалгын үйлчилгээ нэвтрүүлсэн байх		
3.2 Техникийн үйлчилгээ					
11.	Үйлчилгээний зохион байгуулалт	11.1	Эмнэлгийн техникийн албатай, батлагдсан дүрэм, журамтай, мөрддөг байх		
		11.2	Гадны байгууллагаар гүйцэтгүүлэх инженерийн тусламж үйлчилгээг хийж гүйцэтгүүлдэг гэрээтэй байх		

		11.3	Инженер техникийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа явуулах стандартын шаардлага хангасан өрөө тасалгаа, засварын багаж хэрэгсэл, хяналт тохиргооны тоног төхөөрөмжөөр хангагдсан байх		
		11.4	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа ба зардлыг хянадаг, бүртгэлийн сантай байх		
12.	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	12.1	Аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, сургалт явуулдаг, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьдаг байх		
		12.2	Тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг бэлтгэгдсэн ажилтан ажиллуулж, тогтмол шалгаж тохиргоо хийж, бэлэн байдлыг хангадаг байх		
		12.3	Багаж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтын дэвтэр тогтмол хөтөлдөг байх		
		12.4	Шаардлагатай тоног төхөөрөмжинд баталгаажуулалт хийгдсэн байх		
		12.5	Тоног төхөөрөмж бүрийг газардуулгын системд холбож, аюулгүй ажиллагааг хангаж ажилласан байх		
13.	Техникийн хэвийн, аюулгүй ажиллагаа	13.1	Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгүүртэй байх		
		13.2	Эмнэлгийн хийн хангамжийн системд тогтмол хяналт тавьж, цэвэрлэгээ үйлчилгээ хийж, баримтжуулсан байх		
		13.3	Даралтат сав, шугам хоолой хариуцсан ажилтанг томилсон байх		
		13.4	Хийн хангамжийн нэгдсэн шугам, даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх		
		13.5	Цахилгаан, дулаан, усан хангамжийн хэвийн ажиллагааг хангах талаар мэргэжлийн байгууллагуудтай гэрээтэй ажилладаг байх		
14.	Рентген болон туяаны аюулгүй байдал	14.1	Аюулгүй байдлыг хангах зорилгоор багаж, тоног төхөөрөмж, өрөө тасалгааг тогтмол хэмжилт хийж, арга хэмжээ авдаг байх		
		14.2	Туяаны хамгаалалт, аюулгүй арга хэмжээ авч хэвшсэн байх		
15.	Галын аюулгүй ажиллагаа	15.1	Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтад хамруулсан байх		
		15.2	Гал гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай байх		
		15.3	Галын аюулын үед сэрэмжлүүлэх дуудлагын болон дохиоллын хэрэгслээр хангасан байх		
		15.4	Галын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх		

		15.5	Галын хорыг шаардлагатай өрөө, цэгт зохих журмын дагуу байрлуулж, тус бүрт нь техник ашиглалтын паспорт хөтөлсөн байх		
		15.6	Галын хорыг ашигласан болон цэнэглэсэн бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн, мэргэжлийн байгууллагаар цэнэглүүлсэн баримттай байх		

Үнэлгээ:

Шалгуур үзүүлэлтийг 10, 50, 0 оноогоор үнэлнэ.

- Үзүүлэлт бүрийг хангасан бол тус бүрд 100 оноо өгөх ба онооны нийлбэрээр үнэлнэ.
- Үзүүлэлтийг бүрэн хангаагүй бол 50 оноогоор үнэлнэ.
- Үзүүлэлтийг хангаагүй бол 0 оноогоор үнэлнэ.